



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 8/13

Улаанбаатар хот

Г Монгол Улсын Их Сургуульд гадаадын иргэнийг суралцуулах журам батлах тухай

“Дээд боловсролын тухай” хуулийн 12.1.4 дэх заалт, МУИС-ийн Дүрмийн 4.3.8.4 дэх заалт, МУИС-ийн Захиргааны зөвлөлийн 2020 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын Их Сургуульд гадаадын иргэнийг суралцуулах журам”-д нэмэлт өөрчлөлт оруулж, 2020 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.
2. “Монгол Улсын Их Сургуульд гадаадын иргэнийг суралцуулах журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Оюутан солилцоо хөтөлбөрт хамрагдах суралцагчтай байгуулах 3 талт гэрээ”-г 2 дугаар хавсралтаар, “МУИС-д суралцах эрхийн бичиг авсан гадаадын иргэдэд өгөх санамж”-ыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. “Монгол Улсын Их Сургуульд гадаадын иргэнийг суралцуулах журам” шинэчлэн батлагдсантай холбогдуулан МУИС-ийн Захирлын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/499 тоот тушаалаар батлагдсан “Монгол Улсын Их Сургуульд гадаадын иргэнийг суралцуулах журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутан хариуцсан дэд захирал /Б.Очирхуяг/, бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирлууд, нэгжийн удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Я.ТӨМӨРБААТАР

3340301077

Захирлын 2020 оныдугаар сарын-ны
өдрийн //....дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

1117144746
УХД0072 9104399

08

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬД ГАДААДЫН
ИРГЭНИЙГ СУРАЛЦУУЛАХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1 Хоёр улсын Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээр, хамтын ажиллагааны гэрээний дагуу болон хувийн шугамаар суралцах гадаадын иргэнийг Монгол Улсын Их Сургууль (цаашид МУИС гэх)-д суралцуулах үйл ажиллагааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2 Монгол улсын Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон МУИС-ийн холбогдох журмыг үндэслэн МУИС-ийн боловсролын зэрэг олгох болон зэргийн бус сургалтад гадаадын иргэнийг суралцуулахад энэхүү журмыг баримтална.

1.3 Энэ журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал МУИС-ийн захиргааны зөвлөл хэлэлцэж, захирал шийдвэр гаргана.

ХОЁР. Журмын нэр томъёо

2.1. *Боловсролын зэрэг олгох сургалт* нь МУИС-ийн бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтыг хэлнэ.

2.2. Зэргийн бус сургалтад Монгол хэлний бэлтгэл, оюутан солилцоо, мэргэших дадлага (интерншип), зуны сургалтын хөтөлбөрүүдийг хамруулж ойлгоно.

2.3. *Монгол хэлний бэлтгэл хөтөлбөр* гэдэг нь Монгол улсын дээд боловсролын байгууллагад суралцах хүсэлтэй болон монгол хэл суралцах сонирхолтой, тус улсад оршин суугаа гадаадын иргэдэд зориулсан түр хугацааны зэргийн бус сургалтыг хэлнэ.

2.4. *Оюутан солилцооны хөтөлбөр* гэдэг нь МУИС, бүрэлдэхүүн сургуультай хамтын ажиллагааны гэрээтэй гадаадын их, дээд сургуулиас зэргийн болон зэргийн бус хөтөлбөрт ирж суралцах, нөгөө талаас МУИС-ийн суралцагчдаас уг хамтын ажиллагаатай сургуулийн сургалтын хөтөлбөрт хамрагдаж суралцах хөтөлбөрийг хэлнэ. Мөн МУИС, бүрэлдэхүүн сургуулийн хэрэгжүүлж байгаа олон улсын төсөл, хөтөлбөрөөр суралцах суралцагчийг хамааруулна.

2.5. *Зуны сургалтын хөтөлбөр* нь монгол хэл, соёл, орчинтой танилцах, тодорхой чиглэлээр судалгаа хийх хүсэлтэй гадаадын иргэдэд зориулсан богино хугацааны сургалтын хөтөлбөр юм.

2.6. *Мэргэжих дадлага (интерншип)* гэж хамтын ажиллагааны гэрээтэй гадаадын их, дээд сургуулиас болон профессор багшийн хамтарсан судалгааны хүрээнд суралцагч ирж, тодорхой мэргэжил; судалгааны чиглэлээр дадлагажих хөтөлбөрийг хэлнэ.

2.7. Цагаач гэж Монгол улсын эрх бүхий байгууллагаас цагаачлан оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг хэлнэ.

ГУРАВ. Гадаадын иргэнд тавигдах шаардлага

3.1. Монгол улсын харьят бус гадаадын иргэн хаана оршин суугаагаас үл хамааран энэ журмын хүрээнд МУИС-д суралцах хүсэлт гаргаж болно.

3.2. МУИС-ийн боловсролын зэрэг олгох сургалтанд суралцах гадаадын иргэн нь Монгол улсад мөрдөгдөж буй боловсролын агуулгын түвшин, стандарттай дүйцэхүйц өмнөх шатны боловсрол эзэмшсэн байна.

3.3. Гадаадын иргэн нь боловсролын зэрэг олгох сургалтад суралцах бол монгол хэлийг шаардлага хангасан түвшинд эзэмшсэн байх ёстой ба үүнийг нотлох диплом, гэрчилгээний баталгаажуулсан хуулбарыг элсэх хүсэлт гаргах үед ирүүлнэ. Монгол хэлийг тодорхой түвшинд эзэмшсэн боловч түүнийг нотлох бичиг баримт байхгүй бол Монгол хэлний түвшин тогтоо шалгалт (цаашид МХТТШ гэх) өгч болох ба үнэлгээний тодорхой түвшнийг хангасан тохиолдолд зэрэг олгох сургалтанд элсэн суралцана. МХТТШ-ыг цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

3.4. Монгол хэлний зохих шаардлага хангаагүй гадаадын иргэн Монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт хамрагдан, амжилттай төгссөний дараа боловсролын зэрэг олгох сургалтад элсэн суралцаж болно.

3.5. Англи хэлээр сургалт нь явагддаг, боловсролын зэрэг олгох сургалтын хувьд гадаадын иргэнээс монгол хэлний мэдлэг, чадвартай байхыг шаардахгүй боловч, тухайн хөтөлбөрийн шаардлагад нийцсэн англи хэлний түвшинтэй байхыг шаардана. Энэ тохиолдолд англи хэлний мэдлэг, чадварын түвшинг илтгэх бичиг баримтыг (TOEFL, IELTS гэх мэт шалгалтын оноо нь хүчинтэй гэрчилгээ) элсэх хүсэлт гаргах үед хавсаргаж ирүүлнэ.

3.6. Хөтөлбөрийн онцлогоос шалтгаалан бүрэлдэхүүн сургууль, мэргэжлийн тэнхимээс бусад тусгай шаардлагыг элсэгчдэд тавьж болно.

ДӨРӨВ. Элсэн суралцах хүсэлт гаргах

4.1. Боловсролын зэрэг олгох сургалтад хамрагдан суралцах хүсэлтэй гадаадын иргэн нь МУИС-ийн <http://registration.num.edu.mn> хаягаар цахим хэлбэрээр хүсэлт гаргаж бүртгүүлнэ.

4.2. Элсэлтийн үйл ажиллагааг бакалаврын зэрэг олгох сургалтын хувьд хичээлийн жилд нэг удаа, ахисан төвшний сургалтын хувьд хоёр удаа зохион байгуулна.

4.3. Боловсролын зэрэг олгох сургалтын хөтөлбөрийн танилцуулга, элсэлтийн үйл ажиллагаанд холбогдох бусад мэдээллийг МУИС-ийн веб хуудсанд монгол, англи хэлээр байршуулна. Элсэлтийн цахим хуудас нь бүтэн жилийн турш тогтмол ажиллагаатай байж элсэлтийн талаарх мэдээллээр бүртгүүлэгчдийг хангана.

4.4. Элсэн суралцах тухай хүсэлтийг дараах хугацаанд батгаан ирүүлсэн байна.
Үүнд:

4.4.1. Бакалаврын зэрэг олгох хөтөлбөрт элсэх тухай хүсэлтийг 05 дугаар сарын 01-нээс 07 дугаар сарын 20-ны хооронд гаргаж бүртгүүлнэ.

4.4.2. Магистр, докторын зэрэг олгох хөтөлбөрт элсэх хүсэлтийг намрын улиралд суралцах бол 05 дугаар сарын 01-нээс 08 дугаар сарын 20-ны хооронд, хаврын улиралд суралцах бол 10 дугаар сарын 01-нээс 12 дугаар сарын 20-ны хооронд тус тус гаргаж бүртгүүлнэ.

4.5. Гадаадын иргэн адил төвшний хэдэн ч хөтөлбөрт хүсэлт гаргаж болох бөгөөд

цахимаар бүртгэлийн хураамж төлснөөр хүсэлт баталгаажна.

4.6. Элсэн суралцах хүсэлт гаргаж буй гадаадын иргэн дээр дурьдсан хугацаанд багтаан дараах бичиг баримтуудыг бүрдүүлэн цахимаар бүртгүүлнэ. Үүнд:

4.6.1. Элсэх хүсэлт гаргах маягт (загварын дагуу);

4.6.2. Өмнө нь эзэмшсэн боловсролын түвшнийг 1117144746
УХДН072 9164299 илтгэх диплом, дүнгийн хавсралтын хамт (гадаад хэлээрх бичиг баримтыг монгол хэл рүү орчуулж, хуулбарын хамт нотариатаар батлуулсан байх);

4.6.3. Гадаад паспорт (хүчинтэй хугацаа 6 сараас дээш байх);

4.6.4. Монгол улсад суралцах хугацааны сургалтын төлбөр амьдрах зардлыг хариуцах байгууллага, хувь хүнээс гаргасан 1 жилийн сургалтын төлбөр, дотуур байрны төлбөртэй тэнцэх хэмжээний санхүүгийн баталгаа (тэтгэлэг, банкны тодорхойлолт болон түүнтэй дүйцэх баталгаа);

4.6.5. Магистр, докторын хөтөлбөрт элсэх гадаадын иргэний мэдлэг боловсрол, ажлын туршлага, суралцах арга барилыг нь тодорхойлсон удирдах ажилтны болон профессор багшийн тодорхойлолт;

4.6.6. Монгол эсвэл англи хэлний мэдлэг, чадварын түвшинг тодорхойлох гэрчилгээ, сертификат;

4.6.7. Эрүүл мэндийн хуудас (загварын дагуу, сүүлийн 3 сарын дотор эмнэлгээс олгосон байх);

4.6.8. Цээж зураг (сүүлийн 6 сард авахуулсан, 3x4 хэмжээтэй байх).

4.7. Монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт суралцаж буй гадаадын иргэний хувьд сургалт дуусахаас 7 хоногийн өмнө боловсролын зэргийн сургалтад элсэх хүсэлт гаргаж бүртгүүлнэ.

4.8. Бичиг баримт дутуу, өөр агуулгатай бичиг баримт бүрдүүлэх, холбоо барих хаяг тодорхойгүй байх тохиолдолд элсэх бүртгэлээс хасагдана.

4.9. Дээр дурдсан хугацаанаас хэтрүүлэн гаргасан хүсэлтийг хүлээн авахгүй.

ТАВ. Элсэх хүсэлтийг шийдвэрлэх, мэдэгдэх

5.1. Элсэлт бүртгэл хариуцсан нэгж нь суралцах хүсэлт гаргасан гадаадын иргэний бичиг баримтыг хүсэлт гаргах хугацаа дууссанаас хойш долоо хоногийн дотор хянаж, холбогдох хөтөлбөр хариуцсан тэнхимд хүргүүлэх ба элсэлтийн шалгалтыг тэнхимтэй хамтран цахим хэлбэрээр зохион байгуулж шийдвэрлүүлнэ. Суралцуулах эсэх тухай шийдвэрийг Оюутан төгсөгч хариуцсан нэгжид ирүүлнэ.

5.2. Монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт амжилттай суралцан, боловсролын зэрэг олгох хөтөлбөрт элсэх хүсэлт гаргасан гадаадын иргэний элсэлтийн шалгалтыг хөтөлбөрийн сургалт дууссаны дараах долоо хоногт багтаан Элсэлт бүртгэл хариуцсан нэгж нь холбогдох тэнхимтэй хамтран зохион байгуулж шийдвэрлүүлнэ.

5.3. Элсэлтийн шийдвэрийг үндэслэн Оюутан, төгсөгч хариуцсан нэгж нь гадаадын иргэнд МУИС-д суралцах эрхийн бичгийг цахим шуудан, баталгаат шуудангаар илгээх ба холбогдох мэдээллийг өгсөн байна. Илгээх мэдээлэлд Монгол улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтуудыг багтаасан санамж бичиг (загварын дагуу), сургалтын төлбөр, хураамж, дотуур байр, амьдрах орчны талаарх мэдээлэл, сургуульд ирж бүртгэл баталгаажуулах хугацаа зэргийг заавал

дурдсан байна.

5.4. МУИС-д суралцах эрх нь хичээлийн жилийн дараалсан хоёр улиралд хүчинтэй.

5.5. МУИС-д суралцах эрх авсан гадаадын иргэн Оюутан, төгсөгч хариуцсан нэгжээс Монгол улсад суралцах визний холбогдолтой асуудлаар зөвлөгөө авч болно.

5.6. Хоёр улсын Засгийн газар хоорондын болон хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн дагуу суралцах гадаадын иргэдийг БСШУСЯ-ны сайдын тушаалыг УХД072910439 түндэслэн МУИС-ийн Захирлын тушаалаар шууд элсүүлэн суралцуулна.

5.7. Элсэлттэй холбоотой бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн тохиолдолд МУИС-д элсүүлэхгүй бөгөөд элссэн тохиолдолд суралцах эрхийг цуцална.

ЗУРГАА. Суралцагчийг хүлээн авах, бүртгэх, байрлуулах

6.1. МУИС-д суралцах эрх авсан гадаадын иргэн тухайн улирлын хичээл эхлэхээс 7-14 хоногийн өмнө Элсэлт бүртгэл хариуцсан нэгжид биеэр ирж бүртгэлээ баталгаажуулан, МУИС-ийн сургалтын мэдээллийн систем ашиглах хэрэглэгчийн нэр, нууц үгийг авч, гэрээ байгуулна.

6.2. Гэрээнд гадаадын иргэний суралцах хугацаа, тэтгэлэг, сургалтын болон бусад төлбөрийн хэмжээ, амьдрах байр, суралцах орчин, нөхцөл, эрүүл мэнд, даатгалын асуудал, хүлээх хариуцлага болон шаардлагатай бусад асуудлыг тусгасан байна.

6.3. Гэрээ байгуулсан гадаадын иргэнийг МУИС-ийн захирлын тушаалаар элсүүлэн, БСШУСЯ-ны системд бүртгэнэ.

6.4. Бүртгүүлсэн гадаадын иргэн тухайн улиралд суралцах багц цагийн төлбөрөө төлж, хичээл сонголт хийснээр сургалтын зөвлөгөө өгөх ажлыг Элсэлт бүртгэл хариуцсан нэгж нь зохион байгуулна.

6.6. МУИС-д суралцах эрх авсан гадаадын иргэн МУИС-ийн оюутны дотуур байранд амьдрах болон угтах үйлчилгээг авах талаар Оюутан, төгсөгч хариуцсан нэгжид урьдчилан мэдэгдсэн байна.

6.7. Хүсэлтийн дагуу гадаад иргэнийг угтах, тосох, оюутны дотуур байранд байрлуулах, дотуур байранд амьдрах гэрээ байгуулах асуудлыг Оюутан, төгсөгч хариуцсан нэгж хариуцан зохион байгуулна.

6.8. Оюутны дотуур байранд хүсэлт гаргасан гадаад иргэнийг байрлуулахад дараах эрэмбийг баримтална.

6.8.1. Засгийн газар хоорондын болон хамтын ажиллагааны гэрээ,

хэлэлцээрийн дагуу суралцах гадаад иргэн;

6.8.2. Монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт элсэн суралцах гадаадын иргэн;

6.8.3. Бакалавр, магистр, докторын хөтөлбөрт элсэн суралцах гадаадын иргэн;

6.8.4. Бусад.

6.9. Гадаадын иргэнийг Монгол улсад орж ирсэн өдрөөс хойш ажлын 7 хоногийн дотор Гадаадын иргэн харьяатын газарт (цаашид ГИХГ гэх) шаардагдах бичиг баримтыг бүрдүүлэн бүртгүүлж, тус улсад орж ирсэн өдрөөс хойш хуанлийн 21

хоногийн дотор оршин суух зөвшөөрөл авах ажлыг Оюутан, төгсөгч хариуцсан нэгжээхион байгуулж, гадаад иргэний суралцах нөхцөлийг бүрдүүлнэ.

6.10. МУИС-д суралцах эрх авсан гадаадын иргэн хүндэтгэн үзэх шалтгаанаар хичээлийн жилийн тухайн улирлын эхний хоёр долоо хоногт багтаж суралцахаар ирвэл элссэн тухай тушаал гарган, тухайн улирлын хичээлийг судлах эрх өгөх ба дурдсан хугацаанаас хойш ирвэл дараагийн улирлын эхнээс хичээл судлах эрх олгоно.

ДОЛОО. Суралцах үйл ажиллагааг зохицуулах

7.1. МУИС-ийн суралцагч болсон гадаад иргэн Монгол улсын харьяат суралцагчдын нэгэн адил дүрэм, журмаар суралцана.

7.2. Суралцагчийн оршин суух зөвшөөрлийн хугацааг суралцаж буй бүрэлдэхүүн сургууль, нэгжийн тодорхойлолт, сурлагын байдал, гэрээний биелэлт зэргийг үндэслэн жил бүр сунгах асуудлыг Оюутан, төгсөгч хариуцсан нэгж нь зохион байгуулна.

7.2.1. Оюутан, төгсөгч хариуцсан нэгж нь суралцагчийн бүртгэлийг хөтөлж, оршин суух зөвшөөрлийн хугацаа дуусахаас 60 хоногийн өмнө сануулна.

7.2.2. Суралцагч нь оршин суух зөвшөөрлийн хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө өөрийн биеэр Оюутан, төгсөгч хариуцсан нэгжид хандан шаадлагатай материалыг бүрдүүлэн зөвшөөрлийн хугацааг сунгуулах үүрэгтэй.

7.2.3. Оюутан, төгсөгч хариуцсан нэгж нь танхимын сургалтад хамрагдаж буй суралцагчдын оршин суух зөвшөөрлийг дүнгийн мэдээллийг харгалzan жил бүр сунгуулна.

7.2.4. Танхимын сургалтын бүрэн багц цагийг судалж дууссан ахисан төвшний суралцагч нь Монгол улсад судалгааны ажлаа үргэлжлүүлэн хийх тохиолдолд оршин суух зөвшөөрлийг удирдагч багшийн тодорхойлолтыг харгалзан хоёроос дээшгүй удаа сунгуулна. Удирдагч багш үнэнзөв тодорхойлолт болон судалгааны ажлын төлөвлөгөөг гаргаж өгөх үүрэгтэй. Хэрэв эх орондоо буцсан тохиолдолд хамгаалах хугацааг Оюутан, төгсөгч хариуцсан нэгжид урьдчилан мэдэгдэж Монгол улсад нэвтрэх виз авна.

7.2.5. Хуульд заасан хугацаанд сунгуулаагүй тохиолдолд холбогдох хариуцлага, гарах торгууль шийтгэлийг суралцагч өөрөө хариуцна.

7.3. Суралцагч нь өвөл, зуны улирлын амралтаар болон хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөө авч нутаг буцах тохиолдолд холбогдох нэгж, тэнхимд мэдэгдэн, Оюутан, төгсөгч хариуцсан нэгжээр дамжуулан ГИХГ-аас гарах, орох визний зөвшөөрөл авна.

7.4. Монголын бусад их сургуулиас МУИС-д болон МУИС-ийн хөтөлбөр хооронд шилжин суралцах хүсэлтэй суралцагчийн хүсэлтийг "МУИС-д суралцагч шилжүүлэн суралцуулах журам"-ын дагуу шийдвэрлэнэ.

7.5. Зэргийн бус сургалтад хамрагдаж буй гадаадын иргэнийг өөр сургуульд шилжүүлэн суралцуулахгүй бөгөөд шилжин суралцах хүсэлт гаргасан тохиолдолд МУИС-ийн урилгыг цуцалж, сургуулиас хасна.

7.6. Элсэлт, бүртгэл хариуцсан нэгж нь сургууль төгсөх, хасагдах, шилжих, чөлөө авах зэрэг шалтгаанаар сургалтад зогсоосон суралцагчийн төлөв өөрчлөгдсөн мэдээллийг Оюутан, төгсөгч хариуцсан нэгжид мэдэгдэнэ. Оюутан, төгсөгч хариуцсан нэгж нь тухайн суралцагчийн Монгол Улсад оршин суух "S1" ангиллын визийн зөвшөөрлийг цуцалж, хасна. Элсэлт, бүртгэл хариуцсан нэгж нь 7 хоногийн дотор

боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүртгэлд оруулна.

7.7. Гадаадын иргэний МУИС-д элсэн суралцах хүсэлт шийдвэрлэгдсэнээс хойши Монгол улсад ирэх, түр бүртгэлд хамруулах, оршин суухтай холбоотой асуудлууд, зөвлөн чиглүүлэх, дасан зохицох, гэнэтийн ослын болон эрүүл мэндийн даатгалд хамруулах, суралцах хугацааны дэмжлэг үйлчилгээ, **НИЙЭМ**, **УХР00729104399** хөтөлбөрт хамруулах асуудлыг Оюутан, төгсөгч хариуцсан нэгж хариуцна.

НАЙМ. Сургалттай холбоотой төлбөр, хураамж

8.1. Гадаадын иргэний судлах хичээлийн багц цагийн төлбөр, оюутны байрны төлбөр, бусад төлбөр, хураамжийг жил бүр шинэчлэн тогтоож МУИС-ийн Удирдах зөвлөл батална. Сургалтын төлбөрийг суралцагч улирал бүр төлнө.

8.2. Хоёр улсын Засгийн газар хоорондын болон хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн дагуу суралцах гадаадын иргэний сургалтын төлбөр болон амьдрах зардал, даатгал бусад зардлыг гэрээнд заасны дагуу шийдвэрлэнэ.

8.3. МУИС-д суралцаж буй гадаадын иргэн суралцах явцдаа иргэний харьяллаа сольж, Монгол улсын харьяат иргэн болсон бол албан ёсоор Монгол улсын иргэн болсон өдрөөс сургалтын мэдээллийн систем дэх иргэншлийн төлөвийг өөрчилнө. Сургалтын төлбөрийг дараагийн улирлаас эхлэн Монгол суралцагчийн жишгээр тооцно.

8.4. МУИС-д суралцах эрх авсан гадаадын иргэн амь насны, эрүүл мэндийн болон гэнэтийн ослын даатгалыг эх орондоо эсвэл Монгол улсад ирсэн хойно заавал хийнэ.

8.5. Цагаач нь Монгол улсад бүрэн дунд боловсрол эзэмшсэн, Элсэлтийн ерөнхий шалгалт өгч, харгалзах оноогоор элсэн суралцсан бол сургалтын төлбөрийг Монгол улсын харьяат суралцагчдын адилаар төлнө.

ЕС. Монгол хэлний бэлтгэл хөтөлбөр

9.1. Монгол улсын дээд боловсролын байгууллагад суралцах хүсэлтэй болон монгол хэл суралцах сонирхолтой, тус улсад оршин суугаа гадаадын иргэн Монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт суралцаж болно.

9.2. Монгол хэлний бэлтгэл хөтөлбөр анхан, дунд, гүнзгий түвшинтэй байх бөгөөд түвшин бүрийн үргэлжлэх хугацаа хичээлийн жилийн 2 улирлаас хэтрэхгүй байна.

9.3. Монгол хэлний бэлтгэлийн сургалтын хөтөлбөрийг холбогдох мэргэжлийн тэнхим боловсруулан, тэнхимийн хөтөлбөрийн дэд хороогоор хэлэлцүүлж, хөтөлбөр хариуцсан нэгжээр баталгаажуулна.

9.4. Гадаадын иргэн Монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт элсэх хүсэлтийг намрын улиралд суралцах бол 5 дугаар сарын 01-нээс 7 дугаар сарын 20-ны хооронд, хаврын улиралд суралцах бол 10 дугаар сарын 01-нээс 12 дугаар сарын 20-ны хооронд тус тус багтаан ирүүлнэ.

9.5. Элсэн суралцах хүсэлт гаргаж буй гадаадын иргэн дээр дурдсан хугацаанд багтаан дараах бичиг баримтуудыг бүрдүүлэн цахимаар бүртгүүлнэ.

9.5.1. Элсэх хүсэлт гаргах маягт (загварын дагуу);

9.5.2. Гадаад паспорт (хүчинтэй хугацаа 6 сараас дээш байх);

9.5.3. Монгол улсад суралцах хугацааны сургалтын төлбөр, амьдрах зардлыг хариуцах байгууллага, хувь хүнээс гаргасан 1 жилийн сургалтын төлбөр, дотуур байрны төлбөртэй тэнцэх санхүүгийн баталгаа (тэтгэлэг, банкны тодорхойлолт болон түүнтэй дүйцэх баталгаа);

9.5.4. Эрүүл мэндийн хуудас (загварын дагуу, сүүлийн 3 сарын дотор эмнэлгээс олгосон байх);

9.5.5. Цээж зураг (сүүлийн 6 сард авахуулсан, 3x4 хэмжээтэй байх).

9.6. Элсэлт, бүртгэл хариуцсан нэгж нь суралцах хүсэлт гаргасан гадаадын иргэний бичиг баримтыг хүсэлт гаргах хугацаа дууссанаас хойш долоо хоногийн дотор хянаж, шаардлага хангасан гадаад иргэний нэрсийг баталгаажуулан Оюутан, төгсөгч хариуцсан нэгжид ирүүлнэ.

9.7. Оюутан, төгсөгч хариуцсан нэгж нь элсэлтийн шаардлага хангасан гадаадын иргэнд МУИС-д суралцах эрхийн бичгийг цахим шуудан, баталгаат шуудангаар мэдэгдэх ба холбогдох мэдээллийг өгсөн байна. Илгээх мэдээлэлд Монгол улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтуудыг багтаасан санамж бичиг (загварын дагуу), сургалтын төлбөр, хураамж, дотуур байр, амьдрах, орчны талаарх мэдээлэл, монгол хэлний түвшин тогтоо шалгалт авах өдөр, цаг, газар зэргийг заавал дурдсан байна.

9.8. Гадаадын иргэнийг хүлээн авах, бүртгэх, байрлуулах асуудлыг энэ журмын 6-р зүйлд заасны дагуу зохион байгуулна.

9.9. Монгол улсад оршин суугаа гадаадын иргэний хувьд виз, дотуур байрны үйлчилгээнд хамрагдахгүй болно.

9.10. Монгол хэлний хөтөлбөрт суралцах гадаадын иргэний МХТТШ-ыг Монгол улсад ирсний дараа мэргэжлийн тэнхимээс зохион байгуулж, суралцах түвшинг тогтоох бөгөөд сургалтын үйл ажиллагаа нь боловсролын зэрэг олгох сургалттай ижил дүрэм, журмаар явагдана.

9.11. Хөтөлбөрт суралцаж буй гадаадын иргэний оршин суух бүртгэл, зөвлөн чиглүүлэх, даатгалд хамруулах, суралцах хугацааны дэмжлэг үйлчилгээ, нийгэм, соёлын хөтөлбөрт хамруулах зэрэг асуудлыг Оюутан, төгсөгч хариуцсан нэгж хариуцан зохион байгуулна.

9.12. Монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт суралцагчийн судлах хичээлийн багц цагийн төлбөрийг МУИС-ийн Удирдах зөвлөл батлах ба сургалтын төлбөрийг суралцагч улирал бүр төлнө.

9.13. Монгол хэлний бэлтгэл хөтөлбөрт суралцагч нь хичээлийн жилийн эцэст МХТТШ өгөх ба амжилттай төгссөн суралцагч боловсролын зэрэг олгох сургалтад элсэн суралцах эрхтэй болно. Суралцагчийн монгол хэлний түвшингээс шалтгаалан МХТТШ-ийг улирлын эцэст зохион байгуулж болно.

9.14. Боловсролын зэрэг олгох хөтөлбөрт тэнцэх монгол хэлний түвшин, шаардлага, үнэлгээг холбогдох мэргэжлийн тэнхим боловсруулж хөтөлбөрт тусгаж баталгаажуулна.

9.15. Монгол хэлний бэлтгэл хөтөлбөр төгссөн гадаадын иргэнд МУИС-ийн Захирлын тушаалаар гэрчилгээ олгоно. Гэрчилгээ нь тухайн гадаад иргэний монгол хэлний мэдлэгийн түвшинг илэрхийлэх үндсэн баримт бичиг болно.

АРАВ. Оюутан солилцоо, интерншип хөтөлбөр

10.1. Оюутан солилцоо, интерншип хөтөлбөр нь МУИС-ийн гадаадын бусад их дээд сургуультай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний дагуу хэрэгжинэ. Оюутан солилцооны гэрээ нь МУИС-ийн эсвэл бүрэлдэхүүн сургуулийн түвшинд хийгдсэн байна.

1117144746
УУ 00672 814399

10.2. Оюутан, төгсөгч хариуцсан нэгж нь оюутан солилцооны гэрээний бүртгэл, хэрэгжилт, тайлан мэдээг хариуцна. Оюутан, төгсөгч хариуцсан нэгж нь тухайн хичээлийн жилд хэрэгжүүлэх оюутан солилцоо, интерншип хөтөлбөрийн саналыг бүрэлдэхүүн сургуулиас авч нэгтгэн, зар мэдээллийг бэлтгэж, хамтын ажиллагаатай сургуулиудад хүргүүлнэ.

10.3. Оюутан солилцооны хөтөлбөрийг жилд хоёр удаа зохион байгуулах ба гадаадын иргэн хаврын улиралд суралцах бол 10 дугаар сарын 01-нээс 12 дугаар сарын 20-ны хооронд, намрын улиралд суралцах бол 5 дугаар сарын 01-нээс 7 дугаар сарын 20-ны хооронд суралцах хүсэлтээ бүртгэлийн системд цахим хэлбэрээр гаргана.

10.4. Элсэлт, бүртгэл хариуцсан нэгж нь хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргасан гадаадын иргэний холбогдох бичиг баримтыг хүсэлт гаргах хугацаа дууссанаас хойш долоо хоногийн дотор хянаж, холбогдох бүрэлдэхүүн сургууль, тэнхимд хүргүүлэх ба нэгж нь хөтөлбөрт хамруулах тухай шийдвэрийг Оюутан, төгсөгч хариуцсан нэгжид ирүүлнэ. Оюутан, төгсөгч хариуцсан нэгж нь шаардлага хангасан гадаадын иргэний оршин суух зөвшөөрөл, визний үйлчилгээг хариуцна.

10.5. Боловсролын зэрэг олгох болон Монгол хэлний бэлтгэл хөтөлбөр сургалтад хамрагдах дээрх хөтөлбөрийн суралцагчдыг сургалтын мэдээллийн системд бүртгэх ба хүлээн авах, оюутны байранд байрлуулах асуудлыг энэ журмын 6-р зүйлд заасны дагуу зохион байгуулна.

10.6. Хамтын ажиллагааны гэрээний нөхцөлөөс шалтгаалан зэргийн бус сургалтын хэлбэрээр оюутан солилцоо, интерншип хөтөлбөрийг хэрэгжүүлж болох бөгөөд энэ тохиолдолд хөтөлбөрийн агуулга, сургалтын хэлбэр, хугацаа, үйл ажиллагааг харгалзах бүрэлдэхүүн сургууль шийдвэрлэнэ.

10.7. Хөтөлбөрт суралцагчийн дотуур байр, сургалтын төлбөрийн хөнгөлөлт, тэтгэлэг олгох асуудлыг хамтын ажиллагааны гэрээний дагуу шийдвэрлэнэ.

10.8. Хөтөлбөрт суралцаж төгссөн гадаадын суралцагчид дүнгийн тодорхойлолт, гэрчилгээ олгоно.

10.9. Хамтын ажиллагаатай гадаадын их, дээд сургуулийн оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдах МУИС-ийн суралцагчийг МУИС-ийн захирлын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг сонгон шалгаруулна. Уг хөтөлбөрт хамрагдах суралцагчтай Оюутан, төгсөгч хариуцсан нэгж, Элсэлт, бүртгэл хариуцсан нэгж хоорондын гурвалсан гэрээ (загварын дагуу) байгуулна.

10.10. Гэрээнд хөтөлбөрт хамрагдах суралцагчийн суралцах хугацаа, сургалтын төлөвлөгөө, багц цаг, дүн дүйцүүлэлт, төлбөр, үүрэг, хариуцлагыг тодорхой заана. Хамтын ажиллагаатай сургуулиас Оюутан, төгсөгч хариуцсан нэгж, бүрэлдэхүүн сургуульд ирүүлсэн тухайн суралцагчийн суралцсан хугацааны дүнгийн албан тодорхойлолтыг үндэслэн Элсэлт, бүртгэл хариуцсан нэгж нь багц цаг дүйцүүлэлтийг хийж, үргэлжлүүлэн суралцах нөхцөлөөр хангана.

АРВАН НЭГ. Зуны сургалт хөтөлбөр

11.1. Зуны сургалт хөтөлбөрийг бүрэлдэхүүн сургууль, тэнхим, хүрээлэн хариуцаж хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийн мэдээлэл түгээх, сурталчлах, гадаадын иргэнийг бүртгэх, угтах, байрлуулах, танхимиин сургалтад хамруулах зэрэг хөтөлбөрийн хэрэгжилтэд Оюутан, төгсөгч хариуцсан нэгж дэмжлэг үзүүлж ажиллана.

11.2. Зуны сургалт нь батлагдсан хөтөлбөрөөр хэрэгжих ба сургалтын агуулга, хамрах хүрээ, чиглэл, хугацаа, үр дүн зэргийг тусгасан хөтөлбөрийг холбогдох бүрэлдэхүүн сургуулийн захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж батална.

11.3. Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь жил бүрийн 6 дугаар сарын 01-ний дотор хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй гадаадын иргэний мэдээллийг Оюутан, төгсөгч хариуцсан нэгжид ирүүлэх ба шаардлага хангасан гадаадын иргэнд визний зөвшөөрөл авах үйлчилгээг Оюутан, төгсөгч хариуцсан нэгж хариуцна.

11.4. Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь хөтөлбөрт оролцогч гадаадын иргэнийг Монголд ирэх үед сургалтын хөтөлбөрийн агуулга, хугацаа, оролцогчдын хариуцлага, чухал шаардлагатай үед тусламж авах боломж зэрэг мэдээллийг албан танилцуулах ба хөтөлбөрт хамрагдах гадаадын иргэн нь амь насны болон гэнэтийн ослын даатгал хийлгэсэн байна.

11.5. Хөтөлбөрт хамрагдах гадаадын иргэнийг зуны улиралд оюутны байранд байрлуулах боломжтой ба хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж байранд байрлуулах хүсэлтийг жил бүрийн 6 дугаар сарын 15-ны дотор Оюутан, төгсөгч хариуцсан нэгжид ирүүлнэ.

11.6. Уг хөтөлбөрт суралцаж төгссөн гадаадын иргэнд гэрчилгээ олгоно.

11.7. Зуны сургалтын болон оюутны байранд байрлах төлбөрийг жил бүр МУИС-ийн Удирдах зөвлөлөөр хэлэлцэж батална.

11.8. Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь зуны сургалт дууссанаас хойш 14 хоногийн дотор хөтөлбөрийн хэрэгжилт, тайланг Оюутан, төгсөгч хариуцсан нэгжид ирүүлнэ.

11.9. Оюутан, төгсөгч хариуцсан нэгж нь МУИС-ийн зуны сургалтын хөтөлбөрүүдийн мэдээлэл, хэрэгжилт, тайланг нэгтгэх үүрэгтэй ажиллана.

АРВАН ХОЁР. Бусад

12.1. МУИС-д суралцаж буй гадаадын иргэн нь суралцах явцдаа шашин, терроризм, улс төрийн үйл ажиллагаанд оролцохгүй бөгөөд Монгол улсын хууль тогтоомж, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалт, МУИС-ийн дүрэм, журмыг дагаж мөрдөн, Монгол улсын түүх соёл, ёс заншилд хүндэтгэлтэй хандана.

12.2. МУИС-д суралцаж буй гадаадын иргэн нь Монгол улсын хууль тогтоомжийг зөрчсөн нь тогтоогдсон, МУИС-ийн дүрмийн 6.7, МУИС-ийн Сургалтын журмын 4.11.3.2, МУИС-ийн Ёс зүйн дүрмийн 2.4.2 (186, 187) дүгээр заалтыг зөрчсөн тохиолдолд сургуулиас чөлөөлнө.

12.3. МУИС-д өмнө нь суралцах явцдаа Монгол улсын хууль тогтоомж, сургуулийн дотоод дүрэм, журмыг зөрчиж сургуулиас хасагдсан гадаадын иргэн дахин суралцах боломжгүй.

12.4. Оюутан, төгсөгч хариуцсан нэгж нь МУИС-д суралцаж буй гадаадын иргэдийн талаарх судалгааг жил бүр гаргаж бүрэлдэхүүн сургууль, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хургуулнэ.

12.5. Оюутан, төгсөгч хариуцсан нэгж нь оюутан солилцоо хөтөлбөрт хамрагдсан суралцагчдын талаарх судалгааг жил бүр гаргаж Хамтын ажиллагааны хэлтэст хүргүүлнэ.

12.6. МУИС-д гадаадын иргэнийг суралцуулах журмыг түгээмэл хэрэглэгддэг албан ёсны гадаад хэл (англи) дээр орчуулан, үйл ажиллагаанд хэрэглэнэ.
УХД0072 910499

Захирлын 2020 оны 05 дугаар сарын 08-ны
өдрийн 05 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

1117144746
УХД0072 9164399

ОЮУТАН СУРАЛЦУУЛАХ ГУРВАН ТАЛТ ГЭРЭЭ

20...он... сар... өдөр

Дугаар.....

Улаанбаатар хот

Энэхүү “Оюутан суралцуулах гурван талт гэрээ” /цаашид “гэрээ” гэх/-г Монгол улсын их сургууль /цаашид МУИС гэх/ болон их сургуулийн хооронд байгуулсан хамтын ажиллагааны гэрээг үндэслэн нэг талаас МУИС-ийг төлөөлөн Оюутан, төгсгэгчийн хэлтсийн мэргэжилтэн овогтой /цаашид ОТХ гэх/, нэгөө талаас сургуулийн хөтөлбөрийн -р тувшний суралцагч овогтой /цаашид “суралцагч” гэх/, гуравдагч талаас МУИС-ийн Элсэлт, бүртгэлийн хэлтсийг төлөөлж мэргэжилтэн овогтой /цаашид “ЭБХ” гэх/ нар дор дурдсан нөхцөлөөр харилцан тохиолцож байгуулав.

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1 Уг гэрээний зорилго нь МУИС болон их сургуулийн хооронд хамтын ажиллагааны гэрээний хүрээнд солилцоогоор оюутан суралцуулах, оюутан солилцооны хүрээнд өргөн хүрээний мэдлэг, боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэхэд оршино.
- 1.2 Суралцагсдыг солилцооны хөтөлбөрийн мэдээллээр хангах, бүртгэх, сонгон шалгаруулах, оюутны материал бүрдүүлэх, илгээх, гэрээт сургуулиас суралцагчийн суралцахтай холбоотой харилцааг ОТХ нь хариуцан зохион байгуулна.
- 1.3 Оюутан солилцооны хөтөлбөр нь 20... оны ...-ны өдрөөс 20.... оны ...-р сарын -ны өдрийг хүртэл бүтэн жил/хагас жилийн хугацаанд үргэлжилнэ.
- 1.4 Гэрээ дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:
 - 1.4.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн гэж үзсэн тохиолдолд;
 - 1.4.2 Хууль тогтоомжид заасан бусад үндэслэлийг зөрчсөн тохиолдолд.

ХОЁР. Талуудын эрх, үүрэг

2.1 ОТХ дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:

- 2.1.1 Гэрээт сургуультай байнгын харилцаатай байж, суралцагчийн талаархи мэдээллийг холбогдох сургууль, эцэг эх, ар гэрийнхэнд хүргэнэ.
- 2.1.2 Суралцагчид заавар зөвлөгөө өгч, мэдээллээр хангах, удирдан чиглүүлэх үүрэг хүлээнэ.
- 2.1.3 Суралцагчийн дүн, холбогдох бичиг баримтыг шуудангаар хүлээн авах, хүлээлгэн өгнө.
- 2.1.4 Оюутан суралцах явцад үүссэн маргаантай асуудлыг гэрээт сургуультай зөвшилцөн шийдвэрлэх бөгөөд энэ тухай бүрэлдэхүүн сургууль, гэр бүлийн гишүүдэд мэдэгдэнэ.

2.2 Элсэлт, бүртгэлийн хэлтэс дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:

2.2.1 Сургууль хоорондын хамтын ажиллагааны гэрээний дагуу оюутан солилцоогоор МУИС-д суралцагч гадаадын иргэний сургалтын төлбөрийн төлөлт болон бусад мэдээллээр хангах үүрэгтэй.

2.2.2 Сургууль хоорондын хамтын ажиллагааны гэрээний дагуу тухайн гадаадын гэрээт сургуулиас ирж суралцаж буй солилцооны оюутны МУИС-д судалсан багц цагийн тодорхойлолтыг албажуулж олгох ба Монгол хэлний бэлтгэл ангид суралцсан гадаадын гэрээт сургуулийн солилцооны оюутанд суралцахтай холбоотой шаардлагатай бичиг баримтыг албажуулан олгоно.

2.2.3 Сургууль хоорондын хамтын ажиллагааны гэрээний дагуу тухайн гадаадын гэрээт сургуульд суралцсан багц цагийг шилжүүлэн тооцох нөхцөлөөр хангаж ажиллана.

2.3 Суралцагч нь дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Үүнд:

2.3.1 Суралцагч нь Монгол улс болон МУИС-ийн нэрийг өндөрт гарган амжилттай суралцаж, гэрээт хугацаа дуусмагц эх орондоо эргэн ирнэ.

2.3.2 Одоо сурч буй бүрэлдэхүүн сургуульдаа сургалтын төлбөрөө төлсөн байх шаардлагагүй бөгөөд (тухайн гадаадын их дээд сургуультай байгуулсан гэрээний заалтаас хамаарна) солилцооны хөтөлбөрийн хугацаанд гадаадад судалсан багц цагаа тооцуулах эрхтэй.

2.3.3 Гадаадын гэрээт их сургуульд МУИС-аас суралцагч солилцооны оюутан нь буцаж ирсний дараа багц цаг тооцуулахдаа харгалзах багц цагийн төлбөрийг төлсөн байна.

2.3.4 Суралцагч нь суралцах хугацаандаа-ын хууль, тогтоомж болон их сургуулийн дүрэм журмыг сахин биелүүлж, хүндэтгэх шалтгаангүйгээр хичээл таслахгүй байна.

2.3.5 Суралцагч нь өөрийн авч яваа эд зүйлсийн бүрэн бүтэн байх асуудлыг 100 хувь хариуцах бөгөөд эрүүл мэнд, амь насны даатгал хийлгэнэ.

2.3.6 Суралцагч нь эрүүл мэндийн үзлэгт хамрагдах бөгөөд суралцах хугацаанд эрүүл мэнд, гэнэтийн осол, байгалийн элдэв аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлнэ.

2.3.7 Оюутан нь сургалтын хугацаанд хууль бусаар ажил хөдөлмөр эрхлэх, шалтгаангүйгээр хичээл таслахыг хатуу хориглоно.

ГУРАВ. Талуудын хүлээх хариуцлага

3.1 Суралцагч нь гэрээний хугацаа дуусмагц ирээгүй, хууль бусаар амьдрахыг завдсан тохиолдолд МУИС-ийн оюутан байх эрхийг хасаж, улсын цагаачлалын тухай хууль, 2 орны бусад хууль тогтоомж, гэрээ хэлэлцээрийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

3.2 Бүрэлдэхүүн сургууль (Мэргэжлийн тэнхим) нь суралцагчийн багц цагийг журмын дагуу шилжүүлэн тооцох бөгөөд энэ үүргээ биелүүлээгүй тохиолдолд сургууль хоорондын хамтын ажиллагааны гэрээг зөрчсөнд тооцон хариуцлага хүлээлгэнэ.

3.3 OTX нь суралцагчтай холбоотой мэдээллээр оюутны гэр бүл, сургуулийг хангах үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг зөрчсөнд тооцон холбогдох мэргэжилтэнд хариуцлага хүлээлгэнэ.

ДӨРӨВ. Бусад зүйл

4.1 Энэхүү гэрээ нь талуудын гарын үсэг зурснаар баталгаажин хүчин төгөлдөр болно.

4.2 Гэрээг Монгол хэл дээр 3 хувь үйлдэнэ.

4.3 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээрээс гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

4.4 Гэнэтийн буюу давтагдашгүй хүчин зүйлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаандаа гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр холбогдох арга хэмжээ авна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ОТХ-ийг төлөөлж:	Суралцагчийг төлөөлж:	ЭБХ-ийг төлөөлж:
Утас:	Утас:	Утас:

Захирлын 2020 оны 05 дугаар сарын 18-ны
өдрийн 1111 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

1117144746
УХД0072 9104399

МУИС-д СУРАЛЦАХ ЭРХИЙН БИЧИГ
АВСАН ГАДААДЫН ИРГЭДЭД ӨГӨХ САНАМЖ

Элсэгч та дараах мэдээлэлтэй танилцаж, Монгол улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн Монгол улсад нэвтрэх визийн эрх бүхий 4 оронтой кодыг цахим шуудангаар хүлээн авна. Хүлээн авсан кодыг виз мэдүүлэх ЭСЯ, консулын газарт хэлж, Монгол улсад нэвтрэх виз даруулна. МУИС-д элсэх хүсэлт гаргаж байх хугацаанд Монгол улсад оршин суух зөвшөөрөл авсан, ажлын, байгууллагын визтэй бол МУИС-ийн урилгаар виз авах шаардлагагүй болохыг анхаарна уу. Өмнө нь Монгол улсад байх хугацаанд виз, оршин суух зөвшөөрлийн зөрчил гаргасан бол виз олгогдохгүй байх магадлалтайг анхаарна уу.

- Монгол улсад нэвтрэх виз авах:** Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлд зааснаар МУИС-д суралцах эрхийн бичиг авсан гадаадын иргэн нь Монгол улсад нэвтрэх визийн эрх бүхий 4 оронтой кодыг цахим шуудангаар хүлээн авна. Хүлээн авсан кодыг виз мэдүүлэх ЭСЯ, консулын газарт хэлж, Монгол улсад нэвтрэх виз даруулна. МУИС-д элсэх хүсэлт гаргаж байх хугацаанд Монгол улсад оршин суух зөвшөөрөл авсан, ажлын, байгууллагын визтэй бол МУИС-ийн урилгаар виз авах шаардлагагүй болохыг анхаарна уу. Өмнө нь Монгол улсад байх хугацаанд виз, оршин суух зөвшөөрлийн зөрчил гаргасан бол виз олгогдохгүй байх магадлалтайг анхаарна уу.
- Түр бүртгэлд хамрагдах:** Гадаадын иргэний эрх зүйн байдлыг тухай хуулийн 24 дүгээр зүйлд зааснаар Монгол улсын хилээр нэвтэрсний дараа ажлын 3 өдрийн дотор Оюутан, төгсөгч хариуцсан нэгжид (МУИС-ийн хичээлийн 2-р байр, 200 тоот) бичиг баримтын хамт ирж бүртгэлд хамрагдана. Үүнд: паспорт эх хувиар, 1 хувь цээж зураг (4х6хэмжээтэй), 1500 төгрөгний хамт бүртгүүлэх. Хэрэв Та Гадаадын Иргэн Харьяатын Газар (цаашид ГИХГ гэх)-т ажлын 7 өдрийн дотор бүртгүүлэгүй тохиолдолд 2.500.000 төгрөгтэй тэнцэх торгууль төлөх ба цаашид оршин суух зөвшөөрөл авах боломжгүй болохыг анхаарна уу.
- Оршин суух зөвшөөрөл:** Гадаадын иргэний эрх зүйн байдлын хуулийн 27.2.5-д зааснаар түр бүртгэлд хамрагдсаны дараа хуанлийн 14 өдрийн дотор оршин суух зөвшөөрөл буюу оршин суух үнэмлэх авах ёстай. Гадаадын иргэн оршин суух зөвшөөрөл авахдаа Оюутан, төгсөгч хариуцсан нэгжид бичиг баримтын хамт ирж шаардлагатай албан бичгийг аван ГИХГ-т мэдүүлж оршин суух зөвшөөрөл авна. Үүнд: паспорт, паспортын хуулбар, 1 хувь цээж зураг (4х6хэмжээтэй), оршин суугаа хаягийн хорооны тодорхойлолт, оршин суух зөвшөөрөл авах анкет, 36,500 төгрөгний хамт мэдүүлэх. Та дурдсан хугацаанд ирж оршин суух бүртгэл хийгээгүй тохиолдолд хуулийн дагуу хариуцлага хүлээн зөвшөөрч байна.
- МУИС-ийн Зэргийн бус сургалтад хамрагдаж буй гадаад иргэдийг өөр сургуульд шилжүүлэн суралцуулахгүй бөгөөд шилжин суралцах хүсэлт гаргасан тохиолдолд МУИС-ийн урилгыг цуцалж хасалтыг хийхийг анхаарна уу.**

Миний бие овогтой нь дээрх санамжтай танилцаж, Монгол улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн тохиолдолд өөрөө хариуцлага хүлээн зөвшөөрч байна.

Овог нэр:

Паспортын дугаар:

Гарын үсэг:

Он сар өдөр: